



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

дугаар 204

Улаанбаатар

хот

Хүүхдийн цэцэрлэг шинээр
нээж ажиллуулах тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Хотын эрүүлийг хамгаалах газраас шилжүүлсэн яслийн барилгад 140 ортой цэцэрлэг нээж 121, Налайх хотод ашиглалтад орсон 140 ортой цэцэрлэгт Налайх хотын 6 дугаар цэцэрлэг, Найрамдлын районы XIII хорооллын 330 ортой цэцэрлэгт 122, Ногооны комбинатын хөрөнгөөр баригдсан 50 ортой цэцэрлэгийг улсын төсвөөр ажиллуулж 123, Сүхбаатарын районы дэнжийн мянгад ашиглалтад авсан 280 ортой цэцэрлэгт 124 дүгээр цэцэрлэг-ясли гэсэн дугаар тус тус олгож ажиллуулахыг Ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т даалгасугай.

2. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1986 оны 421 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үндсэн дээр үйлдвэр аж ахуйн газраас ажилчдынхаа хүүхдэд зориулан барилга чөлөөлж байгаа санаачилгыг дэмжиж дараах байгууллагын барилга байгууламжинд шинээр цэцэрлэг-ясли байгуулж ажиллуулахыг Ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т зөвшөөрсүгэй. Үүнд:

а/Хэвлэлийн комбинатын бэлтгэсэн байранд 75 ортой цэцэрлэг яслийг 1989 оны 10 дугаар сарын I-нээс нээж 125 дугаар цэцэрлэг-ясли;

б/Холбооны яамны бэлтгэсэн байранд 100 ортой цэцэрлэг-ясли 1989 оны II дүгээр сарын I-нээс нээж 126 дугаар цэцэрлэг-ясли;

в/МАН-ийн 158 дугаар ангийн бэлтгэсэн байранд 75 ортой цэцэрлэг 1989 оны 8 дугаар сарын I-нээс нээж 128 дугаар цэцэрлэг;

г/Барилгын Y техник мэргэжлийн дунд сургуулийн бэлтгэсэн байранд 50 ортой цэцэрлэг 1989 оны 9 дүгээр сарын I-нээс нээж 114 дүгээр цэцэрлэгийн салбар бүлэг;

2.

д/НАХЯ-ны бэлтгэсэн 50 ортой цэцэрлэгт 130 гэсэн дугаар өгч 9 дүгээр сарын 1-нээс нээж тус тус ажиллуулах;

е/СОТ-2-ын монгол барилгын ажилчдын нэгдлийн захиргааны бэлтгэсэн байранд 75 ортой цэцэрлэг 1989 оны 9 дүгээр сарын нээс нээж 131 дүгээр цэцэрлэг;

ж/НАХЯ-ны Хилийн ба Хязгаарын цэргийн 05 дугаар ангийн бэлтгэсэн байранд 75 ортой цэцэрлэг 9 дүгээр сарын 15-наас 24 цагаар нээж 132 дугаар цэцэрлэг

3.Дээрх цэцэрлэгүүдийн төсвийг төлөвлөгөөнд тусгаж санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т даалгасугай.


4.Шинээр байгуулагдсан цэцэрлэгүүдэд хүнсний материалыг зохицуулан хуваарилахыг Төлөвлөгөө, эдийн засгийн хэлтэс /н.Бат/-т үүрэг болгосугай.

5.Шинэ цэцэрлэгүүдэд албан бичгийн тэмдэг хийлгүүлэх, Хавсралт № I-д дурдсан цагаар ажиллуулах арга хэмжээ авахыг Хотын ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

 С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦ-
ЛАГАТАЙ НАРИЙН БИЧИЙН ДАРГА

 Д.АЛТМА